

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, харьяа газрын Удирдах ажилтнуудад болон тэргүүний албан хаагчдад урамшуулал олгох тухай журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмын дагуу нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, харьяа газрын Удирдах ажилтнуудын үйл ажиллагааны үр дүнг дүгнэж, урамшуулалд олгох нийт мөнгөн шагналыг батлагдсан зардлаас гаргахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Ё.Гэрэлчулуун/-т үүрэг болгосугай.

3. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, харьяа газрын тэргүүний албан хаагчдын ажлын үр дүнгийн урамшуулал - гадаад аяллын эрхийн бичгийн зардалд шаардагдах 120.000.000 /нэг зуун хорин сая/ төгрөгийг батлагдсан зардлаас гаргахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Ё.Гэрэлчулуун/-т зөвшөөрсүгэй.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Э.БАТ-ҮҮЛ

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА,
ХАРЬЯА ГАЗРЫН УДИРДАХ АЖИЛТНУУДАД БОЛОН
ТЭРГҮҮНИЙ АЛБАН ХААГЧДАД УРАМШУУЛАЛ
ОЛГОХ ТУХАЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтыг хэрэгжүүлэхэд манлайлан оролцож, үүрэг даалгаврыг амжилттай биелүүлсэн, тогтвортой үр дүнтэй үйл ажиллагаагаар байгууллагыг хангасан, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, харьяа газрын удирдах ажилтнуудын /цаашид “удирдах ажилтан” гэх/, тэргүүний албан хаагчдын үйл ажиллагааны үр дүнг үнэлж, урамшуулахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2. Урамшуулал нь:

- Санхүүгийн батлагдсан эх үүсвэр, эрх зүйн үндэслэлтэй байна.
- Ил тод, нээлттэй, бодит үнэлгээнд үндэслэгдэнэ.
- Ажлын чанар, үр дүнг дээшлүүлэхэд түлхэц болсон байна.

1.3. Энэхүү журмаар дараах удирдах ажилтнуудын үйл ажиллагааг дүгнэж урамшуулна:

- 1.3.1. Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн гишүүд
- 1.3.2. Дүүргийн Засаг дарга нар
- 1.3.3. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн удирдлагууд
- 1.3.4. Нийслэлийн харьяа газрын удирдлагууд
- 1.3.5. Хорооны Засаг дарга нар

1.4 Нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг нь Удирдах ажилтнуудын ирүүлсэн үйл ажиллагааны тайланг үнэлж, судлан, нийслэлийн удирдлагын зөвлөлийн хуралд санал оруулна.

1.5 Ажлын хэсэг нь шаардлагатай бол газар дээр нь очиж танилцах, холбогдох лавлагаа мэдээллийг гаргуулах ажиллагааг зохион байгуулна.

Хоёр. Үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэх

2.1. Удирдах ажилтнуудын үйл ажиллагааны үр дүнд үнэлгээ хийхдээ холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын 2006 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүн, биелэлтийг дүгнэх, мэдээлэх журам”,

2010 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам” болон энэхүү журмыг үндэслэл болгоно.

2.2 Удирдах ажилтнуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ тоон болон чанарын суурь үзүүлэлтийг хамтатган тооцож, шалгуур үзүүлэлт бүр дээр тавигдах гүйцэтгэлийн хувь, дундаж хувийг тодорхойлно.

2.3. Дараах шалгуурыг харгалзан Удирдах ажилтны үйл ажиллагааны үр дүнг тооцно:

2.3.1. Нийслэлийн Удирдлагын Зөвлөлийн гишүүний үйл ажиллагааны үр дүнг энэ журмын нэгдүгээр хавсралтын дагуу үнэлнэ:

- Нийслэлийн Засаг даргатай байгуулсан удирдлагын үр дүнгийн гэрээний биелэлт

2.3.2. Нийслэлийн дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны үр дүнг энэ журмын хоёрдугаар хавсралтын дагуу үнэлнэ:

- Бодлогын зорилтын хэрэгжилт
- Эрүүл аюулгүй байдлын индексийн суурь үзүүлэлтийг бүрдүүлсэн үнэлгээ
- Мэдээллийн ил тод байдал
- Тухайн жилийн зорилтыг хэрэгжүүлэхэд гаргасан шинэ санаа, санаачилга
- Хэрэглэгчдээс өгсөн үнэлгээ

2.3.3. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн удирдлагын үйл ажиллагааны үр дүнг энэ журмын гуравдугаар хавсралтын дагуу үнэлнэ:

- Бодлогын зорилтын хэрэгжилт
- Үндсэн үзүүлэлт
- Мэдээллийн ил тод байдал
- Тухайн жилийн зорилтыг хэрэгжүүлэхэд гаргасан шинэ санаа, санаачилга
- Хэрэглэгчдээс өгсөн үнэлгээ

2.3.4. Хороодын Засаг даргын үйл ажиллагааны үр дүнг энэ журмын дөрөвдүгээр хавсралтын дагуу үнэлнэ:

- Бодлогын зорилтын хэрэгжилт
- Эрүүл аюулгүй байдлын индексийн суурь үзүүлэлт
- Мэдээллийн ил тод байдал
- Тухайн жилийн зорилтыг хэрэгжүүлэхэд гаргасан шинэ санаа, санаачилга
- Хэрэглэгчдээс өгсөн үнэлгээ

2.3.5. Нийслэлийн харьяа газрын удирдах ажилтны үйл ажиллагааны үр дүнг энэ журмын тавдугаар хавсралтын дагуу үнэлнэ:

- Бодлогын зорилтын хэрэгжилт
- Үндсэн үзүүлэлт

- Мэдээллийн ил тод байдал
- Тухайн жилийн зорилтыг хэрэгжүүлэхэд гаргасан шинэ санаа, санаачилга
- Хэрэглэгчдээс өгсөн үнэлгээ

3

2.4. Удирдах ажилтнуудын үйл ажиллагааны үр дүнгийн шалгуурын дэлгэрэнгүй үзүүлэлтүүдийг болон хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын аргачлалыг энэхүү журмын 1-6 дугаар хавсралтаар хавсаргав.

2.5. Ажлын хэсэг нь удирдах ажилтны үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдийн саналыг харгалзан үзнэ.

Гурав. Тайлан хүлээн авах, урамшуулах үйл ажиллагаа

3.1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, харьяа газрын удирдах ажилтан тухайн оны эхний 9 сарын үйл ажиллагааны тайлангаа жил бүрийн 10 дугаар сарын 05-ны дотор Тамгын газарт ирүүлнэ. /Удирдлагын зөвлөлийн гишүүдэд энэхүү заалт хамаарахгүй/

3.2. Тайлан нь энэ журмын 2-р бүлэгт заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийгдсэн байна.

3.3. Дүүргийн Тамгын газар нь Хорооны Засаг дарга нарын үйл ажиллагааны үр дүнг дээрх аргачлалын дагуу дүгнэж, дүүргийн хүн ам, хорооны тооноос хамаарч дараах тоонд нийцүүлэн урамшуулалд хамруулах хорооны Засаг дарга нарын тайланг, үнэлгээний хамтаар ирүүлнэ:

- Баянзүрх дүүргээс 10 хүртэл хорооны Засаг дарга
- Сонгинохайрхан дүүргээс 10 хүртэл хорооны Засаг дарга
- Баянгол дүүргээс 8 хүртэл хорооны Засаг дарга
- Сүхбаатар дүүргээс 6 хүртэл хорооны Засаг дарга
- Чингэлтэй дүүргээс 6 хүртэл хорооны Засаг дарга
- Хан-Уул дүүргээс 5 хүртэл хорооны Засаг дарга
- Налайх дүүргээс 2 хүртэл хорооны Засаг дарга
- Багануур дүүргээс 2 хүртэл хорооны Засаг дарга
- Багахангай дүүргээс 1 хорооны Засаг дарга

3.4 Ажлын хэсэг нь Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, харьяа газрын удирдах ажилтны үйл ажиллагааны үр дүнг энэхүү журамд заасан үзүүлэлт, аргачлалын дагуу үнэлгээ хийж, санал өгөх эрх бүхий албан тушаалтанд танилцуулан, санал дүгнэлтийг нь авсны үндсэн дээр Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

3.4.1. Санал өгөх эрх бүхий албан тушаалтанд:

- Удирдлагын багийн гишүүдийн үйл ажиллагааг Нийслэлийн Засаг дарга;
- Дүүргийн Засаг даргын ажлыг Нийслэлийн Засаг дарга;

- Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд, ОНӨААТҮГ-ын удирдлагуудын ажлыг Нийслэлийн Засаг даргын салбар хариуцсан орлогч;
- Захирагчийн ажлын албаны харьяа газруудын удирдлагуудын ажлыг Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга;
- Хороодын Засаг дарга нарын ажлыг Дүүргийн Засаг дарга нар тус тус тооцно.

4

3.5. Удирдлагын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн Нийслэлийн Засаг даргын захирамжаар удирдах ажилтны урамшуулыг Нийслэлийн өдөр олгоно.

3.6. Удирдах ажилтныг дараах хэлбэрээр урамшуулна.

3.6.1. 80-85 хүртэл хувиар үнэлэгдсэн бол 3 хүртэлх сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 1 удаагийн мөнгөн урамшуулал

3.6.2. 85-90 хүртэл хувиар үнэлэгдсэн бол 3- аас 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 1 удаагийн мөнгөн урамшуулал

3.6.3. 90-ээс дээш хувиар үнэлэгдсэн бол 6-аас 10 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 1 удаагийн мөнгөн урамшуулал

Дөрөв. Тэргүүний албан хаагчдыг урамшуулах.

4.1. Нутгийн захиргааны байгууллага, харьяа газрын удирдах ажилтны үйл ажиллагаанд өгсөн үнэлгээнээс хамааруулж хамгийн өндөр үнэлгээ авсан гурван агентлаг, гурван дүүрэг, 3 хороо, 3 харьяа газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны албан хаагчдыг тус бүр дараах тоонд нийцүүлэн гадаад аялах **гурван сая төгрөгийн** эрхийн бичгээр шагнаж урамшуулна:

4.1.1. Үнэлгээ авсан дарааллын дагуу:

- Дүүрэг:
 1. 3 хүртэл хүн
 2. 2 хүртэл хүн
 3. 1 хүртэл хүн
- Агентлаг
 1. 3 хүртэл хүн
 2. 2 хүртэл хүн
 3. 1 хүртэл хүн
- Хороо
 1. 1 хүртэл хүн
 2. 1 хүртэл хүн
 3. 1 хүртэл хүн

- Харьяа байгуулага
- 1. 3 хүртэл хүн
- 2. 2 хүртэл хүн
- 3. 1 хүртэл хүн тус тус аялах эрхийн бичгээр шагнаана.

4.1.2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар – 3 хүн хүртэл, Захирагчийн ажлын албанаас 1 хүртэл хүнийг тус тус аялах эрхийн бичгээр шагнаана.

4.1.3. Нийслэлийн боловсролын болон эрүүл мэндийн салбарын албан хаагчдыг тухайн байгууллагын тодорхойлт, харьяа дээд газрын шийдвэрийг үндэслэл болгож 3-5 хүртэл хүнийг урамшуулна.

5

4.2. Хамгийн өндөр үнэлгээ авсан гурван агентлаг, гурван дүүрэг, 3 хороо, 3 харьяа газар, Захирагчийн ажлын алба нь энэ журмын 4.1.-д зааасан ажилтнуудын нэрсийг тодорхойлолт, шийдвэрийн хамт Нийслэлийн Засаг даргын тамгын газарт ирүүлнэ.

4.3. Аялах эрхийн бичгийн үнэ болох гурван сая төгрөгийг бэлнээр олгохгүй бөгөөд аялалын зардлыг өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.

4.4. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, тухайн жилийн эдийн засаг, нийгмийн зорилт түүнийг хэрэгжүүлэхэд онцгой үүрэг хүлээж сайн ажилласан, биелүүлэхэд түвэгтэй үүрэг даалгаврыг амжилттай гүйцэтгэсэн, нийслэлийн хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулсан нутгийн захиргааны байгууллага, харьяа газрын удирдах ажилтан, албан хаагчдад Засаг даргын болон Удирдлагын зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн тусгай шагнал олгож болно.

4.5. Шагнал, урамшуулалд зарцуулах хөрөнгийг Нийслэлийн төсөвт жил бүр тусгана.

-----oo0oo-----

Нийслэлийн нутгийн захиргааны
байгууллага, харьяа газрын удирдах
ажилтнуудын болон тэргүүний албан
хаагчдад урамшуулах олгох журмын
нэгдүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН
АЖЛЫН ҮР ДҮНГ ТООЦОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| № | Шалгуур үзүүлэлтүүд | Үнэлгээний дээд оноо |
|----------------|--|-------------------------|
| Удирдлагын баг | | |
| 1 | <ul style="list-style-type: none">- Нийслэлийн Засаг даргатай байгуулсан “Үр дүн”-гийн гэрээнд эрхлэх асуудлын хүрээнд хүлээх үүргийн биелэлт- Нийслэлийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2013 оны зорилтоос хариуцан хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт | 100 |

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага,
харьяа газрын удирдах ажилтнуудын болон
тэргүүний албан хаагчдад урамшуулах
олгох журмын хоёрдугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ТООЦОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| № | Шалгуур үзүүлэлтүүд | Үнэлгээ өгөх нэгж | Үнэлгээний хувь | Үнэлгээний дээд оноо |
|---|--|--------------------------------------|-----------------|----------------------|
| 1 | <p>Бодлогын зорилтын хэрэгжилт:</p> <ul style="list-style-type: none"> - Улсын Их хурал, Засгийн газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргын шийдвэрийн хэрэгжилт - Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт - Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн тухайн жилийн зорилтын хэрэгжилт - Улсын төсөв, зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилт - Нийслэлийн Засаг дарга болон дүүргүүдийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг Орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх ажлын гэрээний гүйцэтгэл, нийслэлийн удирдлагаас цаг үеийн ажил төрлийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт | НЗДТГ-ын ХШҮХ, ХЭЗХ, ТХАХ, СБТХ СТСХ | 100 | 30 |
| 2 | <p>Эрүүл аюулгүй байдлын индексийн үзүүлэлтийг бүрдүүлсэн байдал:</p> <ul style="list-style-type: none"> - Зохион байгуулалтын талаар хийсэн ажил: <ul style="list-style-type: none"> • Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах, эрчим хүч хэмнэх, дулааны алдагдлыг багасгах талаар зохион байгуулсан ажил • Дүүрэгт ЭАБИ тооцох ажлын хэсэг байгуулж баталгаажуулсан эсэх • Холбогдох мэргэжлийн байгууллагуудын оролцоо | НЗДТГ-ын ХШҮХ, НХБХ | 100 | 20 |

| | | | | |
|-----------------|--|------------------------------|----------|----------|
| | <ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагааг явуулах талаар гаргасан шийдвэр • Сургалт зохион байгуулсан эсэх <p>- Мэдээллийн чанар, үнэн бодитой байдал:</p> <ul style="list-style-type: none"> • Эрүүл аюулгүй байдлын индексийн үзүүлэлт, тоон мэдээллүүдийг холбогдох мэргэжлийн байгууллага, агентлагуудаас баталгаажуулсан байх, <p>- Мэдээллийн тайлагналт:</p> <ul style="list-style-type: none"> • Үзүүлэлтүүдийг хугацаандаа ирүүлсэн эсэх, баталгаажилт | | | |
| 3 | <p>Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ:</p> <ul style="list-style-type: none"> - Байгууллагын дотоод удирдлагын програм нэвтрүүлсэн байдал - Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал - Хүний нөөцийн бодлогын ил тод байдал <p>Мэдээллийн үйл ажиллагааны ил тод байдал:</p> <ul style="list-style-type: none"> - Байгууллагын үйл ажиллагаа, бодлого шийдвэрийг цахим хуудсаар мэдээлсэн байдал - Байгууллагын үйл ажиллагааны явцад үүсэн мэдээллийн баазыг “Төрийн байгууллагын мэдээллийн сан”-д байршуулсан байдал <p>Төсөв, санхүүгийн ил тод байдал:</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал - Орон нутгийн хөгжлийн сангийн журмын хэрэгжилт - Иргэний танхимийн үйл ажиллагаа, шууд ардчлал | НЗДТГ-ын ХШҮХ, НЗУХ СТСХ | 100 | 20 |
| 4 | <p>Шинэ санаачилга, үр дүн: (Тухайн байгууллагын үйл ажиллагааны зардал хямдруулах, төсөв хэмнэх бодлогын чанартай арга хэмжээ хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байх)</p> | Ажлын хэсэг | 100 | 10 |
| 5 | <p>Хэрэглэгчийн үнэлгээ</p> <ul style="list-style-type: none"> • Байгууллагынхаа үйл ажиллагааны үр дүнгийн талаар хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг өөрийн “Web” хуудсаар авч дүгнэсэн байдал • Сэтгэл ханамжийн судалгааны мөрөөр зохион байгуулсан ажил, үр дүн • Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал • Хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн байдал | НЗДТГ-ын ХШҮХ, НЗУХ-ийн ИХАТ | 100 | 20 |
| Ерөнхий үнэлгээ | | | 100 хувь | 100 оноо |

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, харьяа
газрын удирдах
ажилтнуудын болон тэргүүний албан
хаагчдад урамшуулах олгох журмын
гуравдугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГИЙН
УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ТООЦОХ
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| № | Шалгуур үзүүлэлтүүд | Үнэлгээ өгөх нэгж | Үнэлгээний хувь | Үнэлгээний дээд оноо |
|---|--|--|-----------------|----------------------|
| 1 | Бодлогын зорилтын хэрэгжилт: - Улсын Их хурал, Засгийн газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргын шийдвэрийн хэрэгжилт - Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт - Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг нийгмийн тухайн жилийн зорилтын хэрэгжилт - Улсын төсөв, зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилт - Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан Үр дүнгийн гэрээний биелэлт, нийслэлийн удирдлагаас цаг үеийн ажил төрлийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт | НЗДТГ-ын ХШҮХ, ХЭЗХ ТХАХ,СБТХ СТСХ | 100 | 30 |
| 2 | Дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилт | НЗДТГ-ын ХШҮХ | 100 | 20 |
| 3 | Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ: - Байгууллагын дотоод удирдлагын програм нэвтрүүлсэн байдал - Үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал - Хүний нөөцийн бодлогын ил тод байдал Мэдээллийн үйл ажиллагааны ил тод байдал: - Байгууллагын үйл ажиллагаа, бодлого шийдвэрийг цахим хуудсаар мэдээлсэн байдал | НЗДТГ-ын ХШҮХ, НЗУХ, СТСХ | 100 | 20 |

| | | | | |
|-----------------|--|------------------------------|----------|----------|
| | - Байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн мэдээллийн баазыг “Төрийн байгууллагын мэдээллийн сан”-д байршуулсан байдал Төсөв, санхүүгийн ил тод байдал: - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал | | | |
| 4 | Шинэ санаачилга, үр дүн: (Тухайн байгууллагын үйл ажиллагааны зардал хямдруулах, төсөв хэмнэх бодлогын чанартай арга хэмжээ хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байх) | Ажлын хэсэг | 100 | 10 |
| 5 | Хэрэглэгчийн үнэлгээ <ul style="list-style-type: none"> • Байгууллагынхаа үйл ажиллагааны үр дүнгийн талаар хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг өөрийн “Web” хуудсаар авч дүгнэсэн байдал • Сэтгэл ханамжийн судалгааны мөрөөр зохион байгуулсан ажил, үр дүн • Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал • Хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн байдал | НЗДТГ-ын ХШҮХ, НЗУХ-ийн ИХАТ | 100 | 20 |
| Ерөнхий үнэлгээ | | | 100 хувь | 100 оноо |

2. ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

Авто замын газар

1. Шинээр баригдсан болон өргөтгөл шинэчлэлт хийгдсэн авто зам, замын байгууламжийг төлөвлөсөн хугацаанд нь чанарын өндөр үзүүлэлттэй ашиглалтанд хүлээлгэн өгсөн байдал, үр дүн
2. Тухайн онд төлөвлөгдсөн хөрөнгө оруулалтыг зориулалтын нь дагуу бүрэн ашигласан байдал, үр дүн
3. Дараа онд баригдах барилга байгууламжийн зураг төслийг урьдчилан хүлээлгэн өгсөн байдал, үрдүн
4. Авто зам, замын байгууламжийн ашиглалтын талаар тухайн жилд хийж гүйцэтгэсэн ажил

Агаарын чанарын алба

1. Агаарт хаягдаж буй хийн хаягдалд хийсэн хэмжилтийн ажил, үр дүн
2. Агаарын бохирдуулагч эх үүсвэрийг тодорхойлсон, нэгдсэн мэдээллийн сан үүсгэсэн байдал, үр дүн
3. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн төслүүдийн үр дүн
4. Агаарын бохирдлын хор холбогдлыг олон нийтэд ойлгуулах, агаарын бохирдлыг бууруулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхээр хийсэн ажил, үр дүн
5. Агаарын бохирдлыг бууруулах талаар зохион байгуулсан хяналтын ажил

Архивын газар

1. Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцлийг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажил
2. Төрийн архивын нөхөн бүрдүүлэлт, тооллого, нягтлан шалгалтын үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн
3. Төрийн архивын баримтын мэдээлэл, эрэлт хайлтын системийг боловсронгуй болгох чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүн
4. Төрийн архивын баримтын ашиглалтын хэлбэр, тэдгээрийг нийтэд ашиглуулах талаар зохион байгуулсан ажил, хүрсэн үр дүн
5. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын архив, бичиг хэргийн бүрдүүлэлтийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэхэд мэргэжлийн арга зүйн удирдлага, зааварчлагаар хангаж зөрчил дутагдалгүй болгож байгаа байдал

Аялал жуулчлалын газар

1. Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, хувийн хэвшлийнхэнтэй байгуулсан хамтын ажиллагааны гэрээ, хамтарч ажиллах төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн
2. Жуулчид, аялал жуулчлалын үйлчилгээний чанарын зэрэглэлтэй байгууллагуудын тоог нэмэгдүүлэх чиглэлээрхийсэн ажил, үрдүн
3. Гадаад, дотоодын иргэдэд нийслэл хотыхоо түүх соёл, үүсэл хөгжлийг таниулан сурталчилах талаар санаачилж хийсэн ажил, үр дүн

Байгаль орчин, ногоон хөгжлийн газар

1. Байгаль орчныг нөхөн сэргээх талаар хийж гүйцэтгэсэн ажил, үр дүн
2. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил, үр дүн
3. Зуслангийн товчооны ажлын хүрээнд
4. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажил, үр дүн

Биеийн тамир, спортын газар

1. Биеийн тамир, спортын эрх зүйн баримт бичиг, материаллаг баазыг бэхжүүлэх талаар шийдвэрлүүлсэн асуудлууд, үр дүн
2. Биеийн тамир, спорт, чийрэгжилтийн талаар зохион байгуулсан сургалт, семинар, хамрагдсан байгууллага, хүний тоо, чанар, үр дүн
3. Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн чиглэлээр нийслэлийн төр, захиргааны болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, их дээд, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, хороодын иргэдийн дунд зохион байгуулсан үйл ажиллагаа, арга хэмжээ, хамрагдсан хүний тоо, чанар, үр дүн
4. Биеийн тамир спортын тухай хуулийн дагуу нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэд байгуулагдсан өсвөр үеийн болон оюутны спортын шигшээ баг, дүүргийн Биеийн тамир спортын хороо, байгууллагуудын үйл ажиллагааг тогтмолжуулж үр дүнд хүргэсэн байдал

Боловсролын газар

1. Сургуулийн өмнөх бага, суурь боловсролд хамрагдалт, нэгдүгээр ангид 6 настай хүүхдийн элсэлт хувь, сургууль завсардалтын бууралтын тоо, харьцуулалт
2. Боловсролын стандартын хэрэгжилтийн байдал
3. Багш нарын мэргэжил дээшлүүлэх системийн бүрдэлт багшийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр хийсэн ажил үр дүн
4. Дүүргийн боловсролын хэлтэс, өмчийн бүх хэвшлийн сургууль, цэцэрлэгт үзүүлсэн мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа, үр дүн

5. Албан бус боловсролын сургалтын чанарыг сайжруулах, хүүхдэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн

Бүртгэлийн газар

1. Төсөвт төвлөрүүлэх торгууль, шийтгэврийн төлөвлөгөөний биелэлт
2. Хороодын иргэний бүртгэлийн ажилтнуудыг мэргэшүүлэх, дадлагажуулах, ур чадварыг дээшлүүлэх, дүүргүүдийн Иргэний бүртгэл, мэдээллийн тасгийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиглэлээр хийсэн ажил, үр дүн
3. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн ХААТР маягтуудыг онлайн системд нэвтрүүлсэн байдал
4. Архивын ХААТР маягтуудын хадгалалт, хамгаалалт, нууцлал, ашиглалтын хувийг сайжруулах зорилгоор цахим архивт шилжүүлэх тапаар хийж гүйцэтгэсэн ажил
5. Бичиг баримтгүй иргэдийг бичиг баримтжуулах, бүртгэлээр илэрсэн зөрчлийг арилгах чиглэлээр хийсэн ажил, үр дүн

Гэр хорооллын хөгжлийн газар

1. Гэр хорооллыг хөгжүүлэх үйл ажиллагаанд оролцож буй төрийн захиргааны байгууллагууд болон олон улсын төсөл хөтөлбөр, зээл тусламжийн оролцоог тодорхойлж, үйл ажиллагаанд татан оролцуулах.
2. Иргэдийн түр зөвлөлөөс гаргасан газар шинэчлэн зохион байгуулах, дахин төлөвлөх төсөл, хөтөлбөрүүдийн саналыг хүлээн авч, хэрэгжих боломжтой төсөл, хөтөлбөрүүдийг нэгтгэж, мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцөн ерөнхий төлөвлөгөөний дагуу
3. Хөрөнгө оруулагч, хувийн хэвшил болон бусад байгууллагуудаас ирүүлсэн хөрөнгө оруулалтын болон төсөл хэрэгжүүлэх санал, төсөл, хөтөлбөрийг хүлээн авч хамтран ажиллах.
4. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу үе шаттай хөгжүүлэх төлөвлөгөө гаргаж, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг тусгуулж хэрэгжүүлэх.
5. Төслийн үйл ажиллагаанд хамаарах иргэн болон хуулийн этгээдийн өмчийн эрх шилжих эрхзүйн харилцаа, хууль эрхзүйн бусад асуудлыг хянан судлах, тэдгээрийг зохицуулах санал боловсруулах, иргэдэд хууль эрхзүйн зөвлөгөө өгөх.

Мал эмнэлгийн газар

1. Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа мал, амыдыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эмчлэх төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн
2. Ям, бруцеллёз, сүрьеэ, лейкоз өвчний шинжилгээ, мал эмнэлэгийн ариутгал, халдваргүйтгэлийн төлөвлөгөөний биелэлт үр дүн
3. Мал аж ахуйн гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний шинжилгээний явц, оношлогоо баталгаажилт бүрэн хийгдсэн байдал, үр дүн
4. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн бүтэц, үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хийсэн ажил, хувийн хэвшлийн мал эмнэлгүүдийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажилласан байдал

Мэдээллийн технологийн газар

1. Мэдээллийн технологийн дэд бүтцийг нутгийн захиргааны байгууллагуудад нэвтрүүлсэн байдал, үр дүн
2. Тусгай хэрэглээний программ хангамжийн ашиглалтын байдал, үр дүн

3. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж программчилах талаар санаачилж зохион байгуулсан ажил, үр дүн
4. Нийслэлийн удирдлага, төр захиргааны байгууллагаас зохион байгуулахаар төлөвлөсөн болон хийсэн ажлын талаар иргэдэд сайт, онлайнаар сурталчилах, иргэдийн санал хүсэлтийг авах чиглэлээр зохион байгуулсан ажил, үрдүн
5. Мэдээллийн технологийг өөрийн байгууллагад нэвтрүүлж, хэрэгжүүлэлт, нийслэлийн төр, захиргааны байгууллагуудад мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлсэн байдал, үр дүн

Мэргэжлийн хяналтын газар

1. Мэргэжлийн хяналтын байгууллагаас эрхлэн явуулдаг хяналтын үйл ажиллагааг зохицуулдаг эрх зүйн баримт бичгүүдийг хэрэгжүүлэх, дагаж мөрдүүлэх зорилгоор бизнес эрхлэгчдийн дунд төрөл бүрийн сургалт зохион байгуулах, гарын авлага материалаар хангахаар хийсэн ажил, үр дүн
2. Салбарын чиглэлээр гарч байгаа хууль тогтоомж, стандартын төсөлд санал өгөх, үйлчлүүлэгчдэд элдэв хүндрэл бэрхшээл учруулж байгаа баримт бичгийг өөрчлөх, хүчингүй болгуулах талаар санаачилсан ажил, үр дүн
3. Дүүргүүдийн Мэргэжлийн хяналтын хэлтсүүдийг ажлын байртай болгох, нөхцлийг сайжруулах, ажиллагсдын ажлын хариуцлага, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах зорилгоор хийсэн ажил, үр дүн
4. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт аюулгүй ажиллагаа, чанар стандарт, технологийн бүхий л шаардлага хангахад хяналтын ажлыг чиглүүлэн үр дүнд хүрсэн байдал
5. Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын чиглэлээр хийгдэж байгаа ажлын чанарыг дээшлүүлэх, хөндлөнгийн хяналт тавихад иргэний нийгэм, ажил мэргэжлийн холбогдох байгууллагуудтай хамтарч авч хэрэгжүүлсэн ажил, үр дүн

Нийгмийн даатгалын газар

1. Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт
2. Нийгмийн даатгалын сангийн орлогын нэр төрлийн төлөвлөгөөний биелэлт
3. Даатгуулагчдын нийгмийн баталгааг хангах, тэтгэвэр тэтгэмж, төлбөр, эмчилгээ үйлчилгээний зардлыг зохих хугацаанд нь олгосон байдал
4. Даатгуулагчдын мэдээллийн баазын бүрдүүлэлт, хамгаалалт, мэдээ тайлангийн гаргалтын байдал
5. Дүүргүүдийн Нийгмийн даатгалын хэлтсийг мэргэжлийн арга зүйгээр хангаж удирдсан байдал

Нийтлэг үйлчилгээний газар

1. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, хэрэгжүүлэгч агентлагуудын аж ахуйн хэвийн үйл ажиллагааг хангаж, ажиллах нөхцлийг бүрдүүлсэн байдал
2. Орчны тохижилт, цэвэрлэгээ, үйлчилгээний стандартын шаардлага хангасан байдлыг агентлагууд, газар хэлтсүүдээр улирал бүр дүгнүүлж тогтмол чанартай үйлчилгээ үзүүлсэн байдал
3. Эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын хэвийн байдлыг хангуулах, эзэмшигчид болон харуул хамгаалалтын ажилтнуудын хариуцлагагүйгээс эд хөрөнгө алдагдаж үрэгдэх явдлаас сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүн
4. Боловсон хүчнийг шилж сонгох, үйлчилгээний ажилчдыг давтан сургах, мэргэшүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар хийсэн ажил

Онцгой байдлын газар

1. Гамшгаас урьдчилан сэргийлэх үзлэг, шалгалт, сургалт, сурталчилгааны ажлын явц, үр дүн
2. Гамшигтай тэмцэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулсан ажлын явц, үр дүн
3. Нийслэлийн хэмжээнд гамшгаас хамгаалах хүч хэрэгслийг бэхжүүлэх, ажиллагсдын бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадавхийг дээшлүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн
4. Дүүргүүдийн Онцгой байдлын хэлтсийг мэргэжил, арга зүйгээр хангаж удирдсан байдал

Өмчийн харилцааны газар

1. Газрын төлбөрийг хураан нийслэлийн төсөвт төвлөрүүлэх
2. Хуульд заасан үндэслэлээр иргэн, хуулийн этгээдийн газар ашиглах, эзэмших эрхийг хүчингүй болгох
3. Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтанд хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх, үргүй зардлыг багасгах арга хэмжээ авах
4. Нийслэлийн өмчийг эзэмшүүлж, ашиглуулах болон өмчийн харилцаатай холбоотой бүх төрлийн гэрээ байгуулах, төлбөр тооцоо хийх, гэрээний биелэлт, эзэмшилт, ашиглалтанд хяналт тавих, илэрсэн зөрчил, маргааныг шийдвэрлэх, хамгаалах ажлыг зохион байгуулж гүйцэтгэх, өмч хөрөнгийн холбогдолтой маргаанд нэхэмжлэгчээр оролцох

Соёл, урлагийн газар

1. Хүн амд үзүүлэх соёлын үйлчилгээний хүртээмж, нийтийн соёлыг дээшлүүлэх талаар хийгдэж буй ажил, үр дүн
2. Түүхийн дурсгалт зүйлийг хадгалж хамгаалах, Соёлын өвийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхээр зохион байгуулсан ажил, үрдүн
3. Улсын чанартай уралдаан, наадамд уран бүтээлчид, ардын авъяастнуудыг хамруулсан байдал, үр дүн
4. Соёл урлагийн ажилтны мэргэжил дээшлүүлэлт болон давтан сургалтын индексийн өсөлт
5. Харьяа соёлын асуудал эрхэлсэн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, иргэдэд үйлчлэх хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн

Статистикийн газар

1. Улсын албан ёсны мэдээлэл гаргах үйл ажиллагаа, үр дүн
2. Улсын хэмжээний тооллого, судалгаа явуулах үйл ажиллагаа, үрдүн
3. Бодлогын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа, үр дүн
4. Бусад үйл ажиллагаа, үр дүн
5. Дүүргүүдийн Статистикийн тасгийг мэргэжлийн арга зүйгээр хангаж ажилласан байдал

Татварын газар

1. Улс, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт, үр дүн
2. Татварын хяналт шалгалтын төлөвлөгөөний биелэлт, үр дүн
3. Татвар төлөгчдийг татварт хамруулалтын түвшин /ҮХХЯ, АТӨЯХАТ/
4. Татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээ, сурталчилгаа
5. Дүүргүүдийн Татварын хэлтсийг мэргэжлийн арга зүйгээр ханган ажиллалт

Тээврийн газар

1. Улаанбаатар хотын нийтийн тээврийн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар хийсэн ажил, үр дүн
2. Нийтийн тээвэрт шинэлэг үйлчилгээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, тээврийн шинэ төрөл нэвтрүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлсэн байдал
3. Нийтийн тээврийн үйлчилгээний сүлжээ, төлөвлөлт, хөдөлгөөний цагийн хуваарийг боловсронгуй, оновчтой болгож чиглэлүүдийн давхцыг бууруулахаар хийсэн ажил, үр дүн
4. Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудтай байгуулсан гэрээний үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн
5. Иргэдээс нийтийн тээврийн үйлчилгээний талаар ирүүлсэн санал, гомдлыг барагдуулах, нийтийн тээврийн үйлчилгээгээр иргэдэд элдэв хүндрэл бэрхшээл учруулахгүй байлгах талаар санаачилж хийсэн ажил, үр дүн

Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар

1. Нийслэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор үйлдвэрлэлийн салбарын кластерыг хөгжүүлэх талаар дэвшүүлж байгаа зорилтын үр дүн
2. Нийслэлийн иргэдийг төмс, хүнсний ногооны тариалан эрхлэлт, борлуулалтыг дэмжих талаар хийсэн ажил үйлчилгээ, чацаргана болон бусад жимс жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх талаар хүрсэн үр дүн
3. Хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэл, тарималын нэр төрлийг нэмэгдүүлсэн байдал, нэгж талбайгаас хураан авсан ургацын хэмжээ
4. Мал аж ахуй эрхлэх зөвшөөрөл бүхий бүсэд эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх ажлыг дэмжиж, дотоодын үйлдвэрлэлээр сүүний хангамжийг нэмэгдүүлсэн байдал, малын үржлийн ажил үйлчилгээ, мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох талаар зохион байгуулсан ажил үр дүн
5. Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилт, хадлан тэжээл бэлтгэх ажлыг хэрхэн зохион байгуулсан байдал

Халамжийн үйлчилгээний газар

1. Халамжийн үйлчилгээний арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо, амьдралын чанарт гарч байгаа өөрчлөлтийн байдалд судалгаа дүгнэлт хийж, бодлогын зорилтод санал, дүгнэлт оруулах чиглэлээр хийсэн ажил, үр дүн
2. Нийгмийн халамжийн сангууд /халамжийн сан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих сан/-ийн зарцуулалтанд хяналт тавьж сангийн зарцуулалтын үр дүнг дээшлүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн
3. Халамжийн үйлчилгээ болон түүнд хамрагдсан иргэдийн талаарх бүртгэл мэдээллийн сан бий болгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хамралтын хүрээг нэмэгдүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн
4. Дүүргүүдийн Халамжийн үйлчилгээний хэлтэс, албадыг удирдлага, арга зүйгээр хангаж ажилласан байдал, үр дүн
5. Иргэдэд төрөөс үзүүлэх халамжийн үйлчилгээний талаар гарсан хууль тогтоомж, холбогдох эрх зүйн баримт бичиг, тэдгээрийг сурталчилсан байдал, үр дүн

Хөдөлмөрийн газар

1. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдсан иргэдийн өсөлтийн байдал (ажилд зуучлах, мэргэжлийн чиг баримжаа олгох мэдээллээр хангах, зөвлөгөө

- өгөх, мэргэжлийн сургалтанд хамруулах, ажил олгогчдод жижиг зээл олгох, ажилгүйдлийн тэтгэмж олгох, өдөрлөг уулзалт зохион байгуулах)
2. Хөдөлмөр, нийгмийн халамжийн сангуудын зарцуулалтанд хяналт тавьж, сангийн зарцуулалтын үр дүнг дээшлүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн
 3. Шинээр бий болгосон ажлын байрны тоо, түүнд хамрагдсан иргэдийн талаар судалгаа мэдээллийг бүрдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ өндөртэй ажлын байрны судалгаа гаргах, ажил хайгчдад мэдээлэл өгөх талаар хийсэн ажил
 4. Дүүргүүдийн Хөдөлмөрийн хэлтэс, албадыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь чанарын ахиц дэвшил гаргах, ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, санаачилгыг дээшлүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн

Худалдан авах ажиллагааны газар

1. Тухайн төсвийн жилд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон цахим хэлбэрээр нийтэд зарлан мэдээлэлд худалдан авах ажиллагааны мэдээ, мэдээлэл, тендер шалгаруулалтын зар үр дүнг нийтэд түгээх вэйб хуудас хөтлөх, түүнд тендерийн урилга, бусад мэдээллийг байршуулах арга хэлбэрийг тогтоох, боловсронгуй болгох талаар хийсэн ажил
2. Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд тулгуурлан төлөвлөж, зохион байгуулан хэрэгжүүлсэн байдал
3. Дүүргүүдийн худалдан авах ажиллагааны албын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажилласан байдал
4. Захиалагч болон тендерт оролцогчдыг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах тэдэнд сургалт зохион байгуулсан байдал
5. Төрийн захиргааны төв, орон нутгийн болон мэргэжлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллах, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж үр дүнг нэмэгдүүлсэн талаар

Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар

1. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудлаарх төрийн бодлого, хууль тогтоомж, дүрэм, журам, холбогдох эрх зүйн баримт бичгүүд болон өөрийн байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж сурталчлах, орон нутгийн болон өөрийн удирдлагын байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангах, хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих замаар гэр бүл, нийгмийг хөгжлийн таатай орчин болгоход чиглэсэн мэдээлэл, нөлөөллийн хамтын ажиллагааг өргөжүүлж төр, хувийн хэвшлийн түншлэлийн харилцааг хөгжүүлсэн байдал үр дүн.
2. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, тогтоомж, дүрэм, журам, холбогдох эрх зүйн баримт бичгүүд болон өөрийн байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, аливаа эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрх ашиг хохирч, зөрчигдсөн үед үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээний тогтолцоог боловсронгуй болгоход талуудтай хамтран ажиллаж оновчтой, үр дүнтэй үйлчилгээ, тусламж, дэмжлэгийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан талаар
3. Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хянах мэдээлэл, судалгааны дэвшилтэт технологид суурилсан хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллыг сайжруулах бодлого, шийдвэрт нөлөөлөхүйц санг бий болгож, үйлчилгээний үр дүнг нийтэд хүртээмжтэй, ил тод мэдээлэх замаар олон нийтийн хяналтын тогтолцоог төлөвшүүлсэн байдал.
4. Байгууллагын гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх, санхүү бүртгэл, төсвийн зарцуулалт, түүний гүйцэтгэлд хяналт тавих, хөрөнгө оруулалтыг сайжруулах, албан хаагчдад нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх замаар хүний нөөцийн чадавхийг

бэхжүүлэх, удирдлагын манлайллыг хангаж, ил тод, авилга, хүнд сурталгүй үйлчилгээ, үзүүлж байгаа талаар.

Цагдаагийн газар

1. Нийслэлийн цагдаагийн байгууллагуудын бие бүрэлдэхүүний ажлын хариуцлага, сахилга батыг дээшлүүлж, ёс зүйг төлөвшүүлэх, ажиллах хүчнээр нөхөн хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил, үр дүн
2. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд иргэд, олон нийт, төр захиргааны байгууллагуудын дэмжлэг, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, үрдүн
3. Гэмт хэргийн илрүүлэлт, түүний дотор хүнд, онц хүнд гэмт хэргийн илрүүлэлтийг ахиулж, гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн хохирлыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлэх, хөрөнгийг хамгаалахад чиглүүлэн зохион байгуулсан ажил, үр дүн
4. Нийслэлийн Цагдаагийн газрын харъяа хэлтэс, албадын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж тэдний үйл ажиллагаанд чанарын ахиц дэвшил гаргах чиглэлээр хийсэн ажил, үр дүн
5. Улаанбаатар хот дахь цагдаагийн эргүүлийг 24 цагийн ажиллагаатай болгож нийслэлийн иргэдийн амар тайван ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил

Эрүүл мэндийн газар

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, үр дүн
2. Эмийн хангамж, чанарт гарсан ахиц дэвшил
3. Дэмжих болон тусламж үйлчилгээний чиглэлээр хийсэн ажил, үр дүн
4. Удирдлагын дэвшилтэт арга барил, байгууллагын хөгжлийн түвшин
5. Дүүргүүдийн Эрүүл мэндийн нэгдлийг мэргэжлийн арга зүйгээр хангаж ажилласан байдал

Эдийн засгийн хөгжлийн газар

1. Нийслэлийн эдийн засгийг хөгжүүлэх бодлого, урт, дунд, богино хугацааны оновчтой төлөвлөгөө, стратеги: Нийслэлийн хөрөнгө оруулалтын бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, хөгжлийн бодлогын уялдааг хангах, үйл ажиллагааг зохион байгуулах: Эдийн засгийн хамтын ажиллагаа, нийслэлийн төсөв, гадаад улс, орон, олон улсын байгууллагын зээл, тусламж; Гадаадын хөрөнгө оруулалтын зохистой, тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн бодлогын хэрэгжилт, үр дүн
2. Хотын бондыг гадаад дотоодын хөрөнгийн зах зээлээс босгох, хөгжлийн болон бусад банкны эх үүсвэрээр хэрэгжүүлэх эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах хөрөнгө оруулалтын төслүүдийг төлөвлөх, зохион байгуулах талаар хийсэн ажил
3. Нийслэлийн эдийн засаг, хөрөнгө оруулалт, худалдааны бодлогыг төлөвлөх, зохицуулалтыг нийслэлийн түвшинд хангах замаар эдийн засгийн өсөлтийн бүтцийг сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, хүн амын амьжиргааны түвшинг нэмэгдүүлэх: Гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламж болон бусад холболгдох төслүүдийг нийслэлийн эдийн засгийн хөгжлийн бодлоготой нягт уялдуулан хэрэгжүүлж, олон нийтийн ашиг сонирхолд чиглэсэн, эдийн засгийн өндөр өсөлтийг хангахуйц гадаад хамтын ажиллагааны бодлогыг хэрэгжүүлэх, эрх зүйн орчинг боловсронгуй болгох;
4. Үндэсний инноваци, концессийн үр ашигтай тогтолцоог нийслэлд бүрдүүлэх, хөгжүүлэх, шинжлэх ухаан, өндөр технологийн ололтыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, төсөл боловсруулах, хөгжүүлэх замаар мэдлэгт суурилсан оюунлаг шинэ

бүтээгдэхүүнүүдийн эдийн засгийн үндсийг тавих, төр, хувийн хэвшлийн түншлэл, концессийн оновчтой бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх, эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр зохион байгуулсан ажил.

5. Нийслэлийн эдийн засгийн хөгжлийн төсвийн бүрдүүлэлт, зарцуулалтанд хяналт тавьж хэрэгжилтийг зохион байгуулах, нийслэлийн эдийн засгийн хөгжлийн хэтийн болон жилийн үндсэн чиглэл, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн төсөл хөтөлбөр, орон нутгийн захиргааны байгууллагад хэрэгжих төсөл боловсруулах, түүнд өөрчлөлт оруулах, хэрэгжилтийн тайлан гаргаж, дүгнэсэн байдал.

Ерөнхий төлөвлөгөөний газар

1. Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, тодотголын хэрэгжилт
2. Газрын эзэмшил, ашиглалт бүртгэлийн үзүүлэлт Газрын байршил, хэмжээг тогтоосон барилга байгууламжийн тоо, техникийн зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлсэн байдал, инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх хөрөнгө оруулалт, техникийн нөхцөл бүрэн олгогдсон барилгын эзлэх хувь хэмжээ
3. Барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон барилгын тоо, ашиглалтад хүлээн авсан барилгын тоо, илрүүлсэн зөрчил, барилгын чанарын үнэлгээ хийсэн барилга байгууламжийн тоо
4. Хот байгуулалтын мэдээллийн сангийн баяжилт, мэдээллээр үйлчилсэн иргэд ААНБ-ын тоо, хаягжилтын ажлын үр дүн
5. Орчин үеийн архитектур, дизайны шийдэлтэй гудамж, зам талбайн зураг төсөл, хаяг рекламны стандарт боловсруулалт, байршил төлөвлөлт, дахин төлөвлөлт хийхээр тогтоосон байршлын тоо, хэрэгжилт, батлагдсан архитектур төлөвлөлтийн даалгавар, батлагдсан зураг төслийн тоо.

Шүүхийн шинжилгээний алба

1. Үзлэг, шинжилгээ, магадлагаа хийж, дүгнэлт гаргасан байдал, чанар үр дүн
2. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр гарын мөр, мөр судлал, гар бичмэл, гарын үсэг, хуурамч баримт бичиг, мөнгөн тэмдэгт, гэмтлийн зэрэг тогтоох зэрэг үзлэг, задлан шинжилгээ, цусны бүлэг, согтолтын хэмжээ тогтоох зэрэг лабораторийн хүчин чадал, шинэжээч мэргэжилтний чадавхид тохирсон үзлэг шинжилгээ хийж дүгнэлт гаргахад ажилласан байдал
3. Алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах ажиллах нөхцөл нийгмийн баталгаа аюулгүй ажиллагаа хөдөлмөр хамгааллын асуудлыг шийдвэрлэхэд санаачилгатай ажиллах.
4. Тухайн нутаг дэвсгэрт үүссэн байгалийн гамшиг, тээврийн хэрэгслийн осол зэрэг онцгой байдал, нийтийг хамарсан арга хэмжээнд ажил үүргийн дагуу оролцсон байдал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба

1. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хуульд зааснаар зохион байгуулж, гүйцэтгэх баримт бичиг бүрт шуурхай ажиллагаа явуулах, бодит биелэлтийг өмнөх оны болон улсын дунджаас бууруулахгүй ажиллах зорилтын биелэлт
2. Төрийн байгууллагын нэхэмжлэлтэй улс, орон нутгийн төсвийн орлогод оруулах гүйцэтгэлийг эрчимжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан талаар
3. Түдгэлзүүлсэн гүйцэтгэх баримт бичгийг харъяа дүүргийн шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтийг нэмэгдүүлэх талаар хийсэн ажил, үр дүн

4. Өртэй этгээдийн бүртгэл хөтөлж, оршин суух хаяг тодорхойгүй төлбөр төлөгч нарын судалгааг дэлгэрэнгүй байдлаар гаргаж, холбогдох байгууллагаа лавлагаа авч эрэн сурвалжлах ажиллагааг шуурхай зохион байгуулан, нийтэд мэдээлэлт

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, харьяа газрын удирдах ажилтнуудын болон тэргүүний албан хаагчдад урамшуулах олгох журмын дөрөвдүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН ХОРООДЫН ЗАСАГ ДАРГА НАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ТООЦОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| № | Шалгуур үзүүлэлтүүд | Үнэлгээ өгөх нэгж | Үнэлгээний хувь | Үнэлгээний дээд оноо |
|---|--|--------------------------------|-----------------|----------------------|
| 1 | Бодлогын зорилтын хэрэгжилт <ul style="list-style-type: none"> - Улсын Их хурал, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилт - Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргын шийдвэрийн хэрэгжилт - Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг нийгмийн тухайн жилийн зорилтын хэрэгжилт - Нийслэлийн удирдлагаас цаг үеийн ажил төрлийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт - Дүүргийн Засаг даргатай байгуулсан Үр дүнгийн гэрээний гэрээний гүйцэтгэл, | НЗДТГ-ын ХШҮХ, ХЭЗХ ТХАХ, СБТХ | 100 | 30 |
| 2 | Эрүүл аюулгүй байдлын индексийн үзүүлэлтийг бүрдүүлсэн байдал <ul style="list-style-type: none"> - Зохион байгуулалтын талаар хийсэн ажил: <ul style="list-style-type: none"> • Хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах, эрчим хүч хэмнэх, дулааны алдагдлыг багасгах талаар зохион байгуулсан ажил • Хороодод ЭАБИ тооцох ажлын хэсэг байгуулж баталгаажуулсан эсэх • Холбогдох мэргэжлийн байгууллагуудын оролцоо • Үйл ажиллагааг явуулах талаар гаргасан шийдвэр • Сургалт зохион байгуулсан эсэх | НЗДТГ-ын ХШҮХ, НХБХ | 100 | 20 |

| | | | | |
|-----------------|--|------------------------------|----------|----------|
| | <ul style="list-style-type: none"> • Газарзүйн байршлын зургийн ажлын явц /гэр хороолол/ - Мэдээллийн чанар, үнэн бодитой байдал: <ul style="list-style-type: none"> • Эрүүл аюулгүй байдлын индексийн үзүүлэлт, тоон мэдээллүүдийг холбогдох мэргэжлийн байгууллага, агентлагуудаас баталгаажуулсан байх, - Мэдээллийн тайлагналт: <ul style="list-style-type: none"> - Үзүүлэлтүүдийг хугацаандаа ирүүлсэн эсэх, баталгаажилт | | | |
| 3 | <p>Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ:</p> <ul style="list-style-type: none"> - Байгууллагын дотоод удирдлагын програм нэвтрүүлсэн байдал - Үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал - Хүний нөөцийн бодлогын ил тод байдал <p>Төсөв, санхүүгийн ил тод байдал:</p> <ul style="list-style-type: none"> - Орон нутгийн хөгжлийн сангийн журмын хэрэгжилт - Иргэний танхимийн үйл ажиллагаа, шууд ардчилал | НЗДТГ-ын ХШҮХ, НЗУХ | 100 | 20 |
| 4 | Шинэ санаачилга, үр дүн (Тухайн байгууллагын үйл ажиллагааны бодлогын чанартай арга хэмжээ хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байх) | Ажлын хэсэг | 100 | 10 |
| 5 | <p>Хэрэглэгчийн үнэлгээ</p> <ul style="list-style-type: none"> • Байгууллагынхаа үйл ажиллагааны үр дүнгийн талаар хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг авч дүгнэсэн байдал • Сэтгэл ханамжийн судалгааны мөрөөр зохион байгуулсан ажил, үр дүн • Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал • Хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн байдал | НЗДТГ-ын ХШҮХ, НЗУХ-ийн ИХАТ | 100 | 20 |
| Ерөнхий үнэлгээ | | | 100 хувь | 100 оноо |

Нийслэлийн нутгийн захиргааны
байгууллага, харьяа газрын удирдах
ажилтнуудын болон тэргүүний албан
хаагчдад урамшуулах олгох журмын
тавдугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ХАРЪЯА ГАЗРЫН УДИРДАХ АЖИЛТНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ТООЦОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| № | Шалгуур үзүүлэлтүүд | Үнэлгээ өгөх нэгж | Үнэлгээний хувь | Үнэлгээний дээд оноо |
|---|--|-------------------------------|-----------------|----------------------|
| 1 | Бодлогын зорилтын хэрэгжилт - Улсын Их хурал, Засгийн газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргын шийдвэрийн хэрэгжилт - Засгийн газрын үйл ажилагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт - Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг нийгмийн тухайн жилийн зорилтын хэрэгжилт - Улсын төсөв, зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилт - Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан Үр дүнгийн гэрээний биелэлт, нийслэлийн удирдлагаас цаг үеийн ажил төрлийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт | НЗДТГ-ын ХШҮХ, ХЭЗХ ТХАХ,СБТХ | 100 | 30 |
| 2 | Дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилт | НЗДТГ-ын ХШҮХ | 100 | 20 |
| 3 | Байгууллагын үйл ажиллагааны ил тод | НЗДТГ-ын | 100 | 20 |

| | | | | |
|-----------------|---|------------------------------|----------|----------|
| | <p>байдлын үнэлгээ:</p> <ul style="list-style-type: none"> - Байгууллагын дотоод удирдлагын програм нэвтрүүлсэн байдал - Үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал - Хүний нөөцийн бодлогын ил тод байдал <p>Мэдээллийн үйл ажиллагааны ил тод байдал:</p> <ul style="list-style-type: none"> - Байгууллагын үйл ажиллагаа, бодлого шийдвэрийг цахим хуудсаар мэдээлсэн байдал - Байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн мэдээллийн баазыг “Төрийн байгууллагын мэдээллийн сан”-д байршуулсан байдал <p>Төсөв, санхүүгийн ил тод байдал:</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал | ХШҮХ, НЗУХ | | |
| 4 | Шинэ санаачилга, үр дүн (Тухайн байгууллагын үйл ажиллагааны зардал хямдруулах, төсөв хэмнэх бодлогын чанартай арга хэмжээ хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байх) | Ажлын хэсэг | 100 | 10 |
| | <p>Хэрэглэгчийн үнэлгээ</p> <ul style="list-style-type: none"> • Байгууллагынхаа үйл ажиллагааны үр дүнгийн талаар хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг өөрийн “Web” хуудсаар авч дүгнэсэн байдал • Сэтгэл ханамжийн судалгааны мөрөөр зохион байгуулсан ажил, үр дүн • Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал • Хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн байдал | НЗДТГ-ын ХШҮХ, НЗУХ-ийн ИХАТ | 100 | 20 |
| Ерөнхий үнэлгээ | | | 100 хувь | 100 оноо |

2. ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

Амьдрах ухаан, сургалт үйлдвэрлэлийн тусгай төв

1. Нийгмийн Халамжийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд: Нийгмийн халамжийн групп тогтоолгох, өндөр настныг асрамжинд асруулах, Хүний хөгжил сангийн тэтгэмжинд хамруулах, ажлын байранд зуучлан оруулах, иргэний бичиг баримтжуулах, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр хийсэн ажил
2. НӨХГ-тай өмч эзэмшилт, түрээсээр байгуулсан гэрээ, түүний биелэлт
3. Олон улсын байгууллагатай хамтран ажилласан байдал, түүний үр дүн
4. Тэнэмэл иргэдийг нийгэмшүүлэхээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, зохион байгуулсан ажил

Хүүхэд, залуучуудын сургалт, хүмүүжлийн тусгай цогцолбор

1. Эцэг эхийн хараа хяналтаас гарсан хүүхдүүдэд халамж, асрамжийн үйлчилгээнд хамруулалт, төвөөр үйлчлүүлж буй хүүхдийн амьдрах тав тухтай нөхцлийг бүрдүүлж орон байр, хоол хүнс, хувцас, эм, хичээлийн хэрэгслэлээр хэрхэн хангаж ажилласан

байдал

2. Нийслэлийн болон дүүргийн захирамжийн дагуу хүүхэд хүлээн авч, хувийн хэрэг хөтлөлт, хүүхэд бүрийг бичиг баримтжуулж, эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байдал
3. Хүүхдүүдэд нөхөн боловсрол эзэмшүүлж албан ба албан бус сургалтанд хамруулан сургууль завсралтыг зогсоон Ерөнхий боловсролын сургуульд, хүүхдүүдийг бие даан амьдрах арга ухаанд сургахад чиглэсэн сургалт, их дээд сургууль болон мэргэжлийн сургалтанд хамруулсан байдал
4. Төвийн харъяа “Од” зуслангийн үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулж, хөгжлийн хөтөлбөрийг хангасан байдал
5. Залуучуудыг нийгэмшүүлэхээр зохион байгуулсан ажил, үр дүн

Монголын хүүхдийн ордон

1. НӨХГ-тай өмч эзэмшилт, түрээсийн талаар байгуулсан гэрээ, түүний биелэлт
2. Дугуйлангуудын сургалт, сэтгэл ханамжийн байдал
3. Хот, улсын хэмжээнд хүүхэд багачуудын авъяас чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэх зорилгоор зохион байгуулж байгаа уралдаан, наадам, арга хэмжээний үр дүн
4. Олон улсын хүүхдийн урлагийн их наадам, фестиваль, чуулга уулзалтанд оролцож үндэсний урлагаа сурталчилсан байдал
5. Сургалт, соёл хүмүүжлийн ажил явуулах тохилог орчин, нөхцөл бүрдүүлэх, материаллаг баазыг бэхжүүлэх талаар хийсэн ажил, үр дүн

Хүүхдийн урлан бүтээх төв

1. НӨХГ-тай өмч эзэмшилт, түрээсийн талаар байгуулсан гэрээ, түүний биелэлт
2. Хүүхэд элсүүлэлт, дугуйлангуудад хамран сургалт, сэтгэл ханамжийн байдал
3. Хот, улсын хэмжээнд хүүхэд багачуудын авъяас чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэх зорилгоор зохион байгуулж байгаа уралдаан, наадам, бүтээл, арга хэмжээний үр дүн
4. Эмзэг бүлгийн болон алслагдсан дүүргийн хүүхдүүдэд тусалж байгаа байдал
5. Сургалт, соёл хүмүүжлийн ажил явуулах тохилог орчин, нөхцөл бүрдүүлэх, материаллаг баазыг бэхжүүлэх талаар хийсэн ажил, үр дүн

Улаанбаатар чуулга

1. Байгууллагын менежментийг боловсронгуй болгох, өмчийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулахаар хийсэн ажил, үр дүн
2. Хөдөлмөрийн гэрээ, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын биелэлт, хамт олон, ажиллагсдын санал, сэтгэгдлийн байдал
3. Хүний нөөцийн бүртгэл, судалгаа, шилжилт хөдөлгөөн, албан хаагчид, уран бүтээлчдийн хувийн хэргийн баяжилтын байдал
4. Албан хаагчид, уран бүтээлчдийн мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, хувийн болон багийн амжилтыг үнэлэх чиглэлээр хийсэн ажил

Гэрлэх ёслолын ордон

1. Хуримын ёслол хийсэн залуу гэр бүлийн тоо болон тэдэнд үйлчилгээ үзүүлсэн байдал
2. Гэр бүлийн боловсролыг дээшлүүлэхээр зохион байгуулсан ажил, үр дүн
3. Үйлчилгээний соёлыг нэмэгдүүлэн хүрээгээ өргөтгөх, орчны тохижилтоор хийсэн ажил
4. Нийгмийн чиглэлийн бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан ажил үйлчилгээний тоо, чанар
5. Байгууллагын менежментийг боловсронгуй болгох, өмчийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулахаар хийсэн ажил, үр дүн

Улаанбаатар музей

1. Байгууллагын менежментийг боловсронгуй болгох, өмчийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулахаар хийсэн ажил, үр дүн
2. Хөдөлмөрийн гэрээ, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын биелэлт, хамт олон, ажиллагчдын санал, сэтгэгдлийн байдал
3. Хүний нөөцийн бүртгэл, судалгаа, шилжилт хөдөлгөөн, албан хаагчид, уран бүтээлчдийн хувийн хэргийн баяжилтын байдал
4. Албан хаагчид, уран бүтээлчдийн мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, хувийн болон багийн амжилтыг үнэлэх чиглэлээр хийсэн ажил

Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл /ОНӨААТҮГ/

1. Хотын нийтийн үйлчилгээ болон инженерийн хангамжийн 24 цагийн болон болзошгүй аюул, аваар ослын үед хүн хүч, техникийн нөөцийн шуурхай зохицуулалтыг хангасан байдал
2. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн тохижилт, усалгаа, чимэглэл, хаягжилт гудамж, зам талбайн ногоон байгууламжийн арчлалт хамгаалалт, усалгаа гэх мэт бүх төрлийн үйлчилгээний чанар түвшин
3. Цэцэрлэгт хүрээлэн, усан оргилуур, үерийн хамгаалалтын далан суваг, барилга байгууламж, авто замын борооны ус зайлуулах шугам болон хөрсний ус зайлуулах барилга байгууламж, насос станц, автозам, замын байгууламжийн ашиглалт, хамгаалалт засвар үйлчилгээ, цэвэрлэгээний байдал
4. Өвлийн улиралд авто болон явган замын хальтиргаа, гулгаа арилгалт, хөшөө, дурсгалын цогцолбор газар, нүхэн гарц, авто замын урсгал тусгаарлах хашаа явган замын арчлалт хамгаалалтаар хийсэн ажил, бодит үр дүн
5. Хог хаягдлын ачилт, тээвэрлэлтийн нэгдсэн хяналт, хог хаягдлын төвлөрсөн цэгийн үйл ажиллагааны байдал
6. Золбин нохой муурын устгалыг шаардлагын хэмжээнд хийн иргэдийн амгалан тайван байдлыг хангаж чадсан эсэх
7. Гэрэлтүүлгийн нэгдсэн удирдлага, хяналтыг хэрэгжүүлэлт
8. Асфальтбетон, хайрга, сайжруулсан хөрс үйлдвэрлэл болон хар шорооны карьер нийтийн эзэмшлийн тавилгын засвар, үйлдвэрлэл /үүний дотор тэмдэг, тэмдэглэгээ, урсгал тусгаарлах хайс, рекламны самбар, сандал, хогийн сав зэрэг багтана/-ын үйл ажиллагаа хэвийн лавшарсан эсэх
9. Автомашины төлбөртэй зогсоол ажиллуулсан байдал

Хэсэгчилсэн инженерийн ХАНГАМЖИЙН УДИРДАХ газар /ОНӨААТҮГ/

1. Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй хэрэглэгчдийг дулааны эрчим хүч үйлдвэрлэн хангасан байдал
2. Нийслэлийн нутаг дэвсгэр дээрх нийт халаалтын зуухнуудын техникийн бодлогыг тодорхойлох, хяналт тавих, хэвийн найдвартай ажиллагааг хангуулах талаар зохион байгуулсан ажил
3. Гэр хорооллын да хин төлөвлөлт хийгдэж буй байршлуудад хэсэгчилсэн инженерийн хангамж болон бага оврын цэвэрлэх байгууламж, гадна шугам сүлжээ, орон сууцны цэвэр ус, цахилгаан сантехникийн ашиглалт, засвар үйлчилгээ үзүүлсэн байдал
4. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хэсэгчилсэн инженерийн байгууламжид эко технологи нэвтрүүлэн эдийн засгийн үр ашигтай систем бий болгох, цэвэрлэх байгууламжаас гарах саарал ус, лагийг ашиглах нөхцөл бүрдүүлсэн байдал .

Ус сувгийн удирдах газар

1. Нийслэлийн хүн ам, байгууллага, аж ахуйн нэгжийг унд, ахуйн хэрэгцээний цэвэр усаар тасралтгүй хангах үүргийн биелэлт
2. Олборлож байгаа усанд лабораторийн хяналтыг тогтмол тавьж, стандартын шаардлага хангасан аюулгүй цэвэр усыг хэрэглэгчдэд нийлүүлсэн байдал
3. Хэрэглэгчдээс гарсан бохир усыг татан зайлуулах, зөвшөөрөгдөх хэмжээний бохирдолтой бохир усыг экологийн шалгуурт тохирохуйцаар цэвэршүүлж байгальд нийлүүлэх талаар хийж гүйцэтгэсэн ажил, үр дүн
4. Тоног төхөөрөмжийн ашиглалтын бэлэн байдлын түвшинг 95.0 хувиас бууруулахгүйгээр нийт системийн ашиглалтын хэвийн найдвартай ажиллагааг хангах зорилтын хэрэгжилт
5. Улаанбаатар хотын ундны усны эх үүсвэрийн ариун цэвэр, аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын бүсийн дэглэмийг сахиулах, цэвэр усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлээр талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ
6. Станцуудад болон лагийн иалбайд хуримтлагдсан лагийг тухай бүр цэвэрлэсэн байдал, лагийг шахаж усгүйжүүлснээр ил задгай талбайд хаягдлыг таслан зогсоож, эрүүл орчин бүрдүүлсэн эсэх.

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар

1. Харилцагч байгууллагууд болох Ус сувгийн удирдах газар, Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ, Дулааны сүлжээ ХК-тай хамтран хотын хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил, үр дүн
2. Инженерийн шугам сүлжээний их болон урсгал засвар хийхээр тухайн жилд төлөвлөсөн ажлын биелэлт, үр дүн
3. Системийн хэмжээнд шинэ техник, технологи нэвтрүүлж байгаа төслийн ажлын хэрэгжилт, үр дүн
4. ОСНААУГазар түүний харъяа салбар, компаниудын санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, хяналт тавьсан байдал
5. Хүний нөөцийн бодлого, инженер техникийн ажилчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр хийж буй ажил, үр дүн

Улаанбаатар лифт /НӨҮГ/

1. Лифтийн ашиглалт, засвар үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, шинэ терник технологи нэвтрүүлэх, бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх зөвлөмж, аргачлал, удирдамж боловсруулж ажилласан байдал
2. Олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд аж ахуйн гэрээний үндсэн дээр лифтийн магадлал туршилтын ажлыг Улаанбаатар хотын лифтэнд хэрэгжүүлж ажиллаж байгаа эсэх
3. Улс, орон нутгийн төсвөөр шинэчлэгдэж буй лифтийн зураг төсөв, боловсруулах, захиалагчийн хяналт хийх зохион байгуулсан талаар
4. Лифтийн ашиглалт үйчилгээний салбарыг мэргэжилтэй боловсон хүчнээр бэхжүүлэх, тэдний мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, гадаад дотоодын сургалтанд хамруулах, ажилтнуудыг байнгын курсээр бэлтгэх, давтан сургах зэрэг боловсон хүчний нэгдсэн бодлого явуулж байгаа байдал
5. Үйлдвэрлэлийн цехийн материаллаг баазыг өргөтгөн орчин үеийн машин, механизм, шинэ техник технологийг нэвтрүүлэн өргөтгөн бэхжүүлж хүчин чадлыг нь бүрэн ашиглаж, лифтийн сэлбэг үйлдвэрлэх, засварлах, угсрах зэргээр аж ахуйн үйл ажиллагааг тогтмолжуулах.

Замын хөдөлгөөний удирдлагын төв

1. Тухайн жилийн үйл ажиллагаанд төлөвлөгдсөн хөрөнгө оруулалтыг зориулалтаар нь, үр бүтээлтэй ашигласан байдал
2. Замын хөдөлгөөний нөхцөл, тээврийн хэрэгслийн ачааллын судалгаанд үндэслэн хөдөлгөөний аюулгүй байдал, замын хөдөлгөөний менежментийн санал боловсруулан хэрэгжүүлэлт
3. Улаанбаатар хотын замын хөдөлгөөн зохицуулж байгаа техник хэрэгслийг бүрэн бүтэн ажиллуулж, засвар арчлалтыг тухай бүр хийснээр замын хөдөлгөөний бөглөрөлийг багасгасан байдал, үр дүн
4. Замын хөдөлгөөний нөхцөл байдлыг холбогдох байгууллага болон иргэдэд түргэн шуурхай, үнэн зөв мэдээлж, хамтран ажилласан байдал

Нийслэлийн төр, захиргааны авто бааз

1. Албан хэрэгцээнд авто машин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан, байгууллагатай ажил, үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж, дүгнэсэн байдал
2. Үйлчилгээнд явуулж байгаа авто тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, үйлчилгээний соёлд тавигдах шаардлага, стандарт норм нормативыг мөрдөж, шуурхай, чирэгдэлгүй үйлчлэх
3. Санхүүгийн анхан шатны бүртгэлийг хөтөлж, тайлан тэнцлийг зохих хугацаанд гаргалт
4. Байгууллагын менежментийг боловсронгуй болгох, өмчийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулахаар хийсэн ажил, үр дүн

Зураг төслийн хүрээлэн

1. Барилга, хот байгуулалтын талаар нийслэлээс хэрэгжүүлж буй бодлогыг дэмжин ажиллаж буй байдал, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж ажилласан байдал
2. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийн боловсруулах ажлын явц, үр дүн
3. Төлөвлөсөн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тоо, биелэлт
4. Төлөвлөсөн зам, барилга, их засварын зураг төслийн биелэлт

“Улаанбаатар” Бизнес хөгжлийн төв

1. Үртсэн түлшний иж бүрэн цогцолбор үйлдвэрийг хэвийн ажиллуулж буй эсэх
2. Түлшний борлуулалтын менежмент, үр дүн
3. Нийслэлийн төр, захиргааны 3 дугаар байрын ашиглалт, засвар, үйлчилгээ
4. Түрээсийн орлого бүрдүүлэлт, гэрээний үүргийн биелэлт

Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв НӨУҮГ

1. Нийслэлийн хэмжээнд үйлдвэрлэл үйлчилгээ явуулж байгаа жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг бүртгэлжүүлж тэдэнд мэргэжлийн арга зүй, зөвлөгөө өгч ажилласан байдал
2. Шинээр бизнес эрхлэгчдийг төвд бойжуулан цаашид тогтвортой ажиллах чадавхи бүрдүүлсэн байдал, үр дүн
3. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүн
4. Бизнес инкубаци төвүүд байгуулах, өмнө байгуулагдсан төвүүдийн үйл ажиллагааг жигдрүүлэх
5. Олон улсын болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж шийдвэрлэсэн ажил, үр дүн

Автобус-1 компани

1. Зорчигч тээврийн орлогын төлөвлөгөөний биелэлт
2. Шугамд явах цагийн график мөрдөлт
3. Рейс, маршрутын зөрчил гаргасан эсэх
4. Техникийн бэлэн байдал, парк шинэчлэлт
5. Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлын үр дүн
6. Техникийн аюулгүй ажиллагааны мөрдөлт

Автобус-3 компани

1. Зорчигч тээврийн орлогын төлөвлөгөөний биелэлт
2. Шугамд явах цагийн график мөрдөлт
3. Рейс, маршрутын зөрчил гаргасан эсэх
4. Техникийн бэлэн байдал, парк шинэчлэлт
5. Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлын үр дүн
6. Техникийн аюулгүй ажиллагааны мөрдөлт

Цахилгаан тээвэр компани

1. Зорчигч тээврийн орлогын төлөвлөгөөний биелэлт
2. Шугамд явах цагийн график мөрдөлт
3. Рейс, маршрутын зөрчил гаргасан эсэх
4. Техникийн бэлэн байдал, парк шинэчлэлт
5. Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлын үр дүн
6. Техникийн аюулгүй ажиллагааны мөрдөлт

Гэр хорооллын орон сууцжуулах төслийн нэгж

1. ГХОСТ-ийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь гэр хорооллын бүсийг нийгэм эдийн засаг, байгаль орчны зохистой харьдааг хангах суурьшлын бүс болгон хөгжүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулах.
2. Хариуцсан ажил үүргийн чиглэлээр гэр хорооллыг хөгжүүлэх, төлөвлөх, орчноо тохижуулах үйл ажиллагаанд газар өмчлөгч, эзэмшигч иргэдийн оролцоог ханган, тэдний үүсгэсэн бүлэг, зөвлөлийн гаргасан санал санаачлагыг хөгжпийн төсөл, хөтөлбөрт тусгах, хамтран ажиллах.
3. Гэр хорооллыг хөгжүүлэх үйл ажиллагаанд байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлэгч хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах.
4. Гэр хорооллын бүсэд нийгмийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ шинэчлэх, байгуулах ажлыг зохион байгуулах.
5. Гэр хорооллыг хөгжүүлэх талаар гаргасан хууль, тогтоомж, шийдвэр, төлөвлөсөн бодлого, авч буй арга хэмжээ, хэрэгжүүлэх төсөл, түүний үр дүнгийн талаар олон нийтэд сурталчлах.
6. Гэр хорооллын бүсэд газар шинэчлэн зохион байгуулах, дахин төлөвлөх асуудлыг судлан эрх бүхий байгууллагуудад санал болгох.
7. Гэр хорооллын бүсэд ашиглалтын шаардлага хангахгүй болсон барилга байгууламжийг буулган шинээр барилгажуулах ажлыг холбогдох шийдвэрийн дагуу зохион байгуулах.
8. Иргэдийн оролцоотой хийгдсэн дахин төлөвлөлтийн дагуу явагдах барилгын ажлын хугацаанд зайлшгүй шаардлага бүхий айл өрхийг түр оршин суух байраар хангах ажлыг зохион байгуулах.

1. Нийслэл улаанбаатар хотын нийтийн аж ахуйг өргөтгөх, хот тохижилтыг сайжруулах, хүн амын үйлчилгээг боловсронгуй болгох, нийгмийн асуудлыг сайжруулах, экологи байгаль орчныг хамгаалах зорилгоор үйлдвэрлэл, худалдаа, аялал жуучлалын зэрэг үйл ажиллагаа явуулсан байдал
2. Хотын төсвийн ачааллыг багасгах, санхүүгийн хөрөнгийг арвижуулах зорилгоор төсөл, боловсруулах, хэрэгжүүлэх, тендер зарлах, сугалаа, хувьцаа, үнэт цаас гаргах зэрэг үйл ажилласан явуулсан байдал
3. Олон улсын байгууллага, гадаад орны засаг захиргаа, бизнесийн болон төрийн бус байгууллагатай хамтран компаний үндэс үүрэгт нийцсэн хүрээнд үйл ажиллагаа явуулсан байдал

Хөрөнгө оруулалтын газар /НӨҮГ/

1. Тухайн жилд шинээр барих барилга угсралтын ажлын явц, үр дүн
2. Их засварын ажлын гүйцэтгэл, төлөвлөгөөт хугацаанд ашиглалтанд өгсөн байдал, үр дүн
3. Захилагчийн хяналтын хэрэгжилт, хугацааны мөрдөлт
4. Мэргэжлийн чиг үүрэг бүхий байгуулагуудын ажлын уялдаа, хамтран ажилласан байдал
5. Ажилтнуудын ажил хариуцах чадвар

Үндэсний цэцэрлэгт хүрээлэн НӨҮГ

1. Цэцэрлэгт хүрээлэнд хийсэн бүтээн байгуулалтын ажлын явц, үр дүн
2. Цэцэрлэгт хүрээлэнд тарьсан мод, бут сөөгийн арчлалтын байдал, үр дүн
3. Ногоон байгууламж цэцэрлэгжилтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага , аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний хэрэгжилт
4. Гадаадын орнуудтай ногоон байгууламжийг арчлах, хамгаалах талаар хамтарч ажилласан байдал, үр дүн

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН АРГА, АРГАЧЛАЛ

Үнэлгээний аргачлал:

1. Тоогоор илэрхийлж үнэлэх боломжгүй тухайн шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн хувийг тогтоохдоо дараах зарчимд үндэслэнэ:
2. Тухайн ажил (зорилт)-ын гүйцэтгэл нь тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, энэ талаар холбогдох шийдвэр, үр дүн гарч, тогтворжсон бол 100 хувь;
3. Ажлын гүйцэтгэл нь тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90.0 хувь (80.0- 100.0 хүртэл хувь);
4. Тавьсан зорилтод хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол гүйцэтгэлийн байдлыг харгалзан 70.0 хувь (60.0 - 80.0 хүртэл хувь);
5. Тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол хийгдэж байгаа ажлын түвшинг харгалзан 50.0 хувь (40.0 - 60.0 хүртэл хувь);
6. Тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол хийгдэж байгаа ажлын түвшинг харгалзан 30.0 хувь (20.0-40.0 хүртэл хувь);
7. Тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон арга хэмжээг авч эхэлж байгаа бол ажлын түвшинг харгалзан 10.0 хувь (0.0 - 20.0 хүртэл хувь);
8. Тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийн хувийг 0.0 хувь гэж үзнэ.
9. Үнэлгээг үйл ажиллагааных нь хүрсэн түвшин, хэрэгжүүлсэн ажлын үр дүн, чанар, хүртээмж зэргээс нь хамаарч 0-оос 100 хүртэл хувиар тооцож Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст ирүүлнэ.

$$\text{Дундаж үнэлгээ} = \frac{\text{Шалгуур үзүүлэлт}_1 + \text{Шалгуур үзүүлэлт}_2 + \dots + \text{Шалгуур үзүүлэлт}_n}{n}$$

$$\text{Ерөнхий үнэлгээ} = \frac{\text{Дундаж } Y_1 \times 20 + \text{Дундаж } Y_2 \times 20 + \text{Дундаж } Y_3 \times 20 + \text{Дундаж } Y_4 \times 10 + \text{Дундаж } Y_5 \times 30}{100}$$

Үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээг дараах байдлаар ангилна.

| | |
|--------------------------------|--------------|
| ✓ Бүрэн хангалттай | 90.0 - 100.0 |
| ✓ Хангалттай | 80.0 - 89.9 |
| ✓ Ажил сайжруулах шаардлагатай | 70.0 - 79.9 |
| ✓ Хангалтгүй | 0.0 - 69.9 |

Байгууллага, нэгжүүдийн үйл ажиллагааны

үнэлгээний үлгэрчилсэн загвар

| д/д | Шалгуур үзүүлэлтүүд | | Үнэлгээний хувь | Үнэлгээний оноо |
|--|---|---|-----------------|-----------------------|
| 1. | А. Бодлогын зорилт | Шалгуур үзүүлэлт -1 | 93.5 % | Авбал зохих оноо 20.0 |
| | | Шалгуур үзүүлэлт - 2 | 86.7 % | |
| | | Шалгуур үзүүлэлт - 3 | 94.6 % | |
| | | Шалгуур үзүүлэлт - 4 | | |
| | | Шалгуур үзүүлэлт - 5 | | |
| Дундаж үнэлгээ | | | 90.8 % | 18.3 |
| 2. | Б. Эрүүл аюулгүй байдлын индекс | Шалгуур үзүүлэлт -1 | 89.2 % | Авбал зохих оноо 20.0 |
| | | Шалгуур үзүүлэлт - 2 | 95.0 % | |
| | | Шалгуур үзүүлэлт - 3 | 92.4 % | |
| Дундаж үнэлгээ | | | 91.9 % | 19.3 |
| 3. | В. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал | Шалгуур үзүүлэлт -1 | 97.0 % | Авбал зохих оноо 20.0 |
| | | Шалгуур үзүүлэлт - 2 | 88.3 % | |
| | | Шалгуур үзүүлэлт - 3 | 91.6 % | |
| Дундаж үнэлгээ | | | 92.3 % | 19.2 |
| 4. | Г.Шинэ санаачилга, үр дүн | Тухайн байгууллагын үйл ажиллагааны зардал хямдруулах, төсөв хэмнэх бодлогын чанартай арга хэмжээ хэрэгжүүлж, үр дүнг төсвөөс бийл | 88.3 % | Авбал зохих оноо 10.0 |
| | | Дундаж үнэлгээ | | |
| 5 | Д. Хэрэглэгчийн үнэлгээ | Байгууллага, нэгжүүдийн үйл ажиллагааны үр дүн, иргэдэд үзүүлж буй төрийн ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн түвшингийн талаар иргэдээс өгсөн үнэлгээ, сэтгэл ханамжийн судалгааны дүн | 84.5 % | Авбал зохих оноо 30.0 |
| | | Дундаж үнэлгээ | | |
| Ерөнхий үнэлгээ | | | | 92.6 |
| <i>(Дундаж үнэлгээ + Дундаж үнэлгээ₂ +..... Дундаж үнэлгээ)</i> | | | | |

(Жич: Энэхүү загварт ашигласан үнэлгээний хувь, оноо нь жишээ загвар болохыг анхаарна уу.)